

МОНГОЛ ХЭЛНЭЭ ӨГҮҮЛБЭРИЙН УТГЫГ
ҮГҮЙСГЭН ЗАХИРАХУЙ (Negative imperative)

Д. Энхжаргал¹

Түлхүүр үг: үгүйсгэл, үгүйсгэн захирахуй, үгүйсгэл тэмдэглэгч

Монгол хэл шинжлэлд үгүйсгэлийг цөөнгүй эрдэмтэн судалсан хэдий ч утгын хэв шинжийн судалгаа зайлшгүй шардлагатай байна. Монгол хэлний үгүйсгэлийг Ш. Лувсанвандан (1968), Wonsoo Yu (1991), Ю. Мөнх-Амгалан (1998), Б. Пүрэв-Очир (2001, 1998), П. Бямбасан (2006) Ж. Бат-Ирээдүй (2009) Э. Равдан (2009) нар судалж, өөрсдийн санал, дүгнэлтийг гаргажээ.

Ерөнхий хэл шинжлэлд утгын хувьд үгүйсгэлийг өгүүлбэрзүйн түвшинд авч үздэг бөгөөд өгүүлэмж, дискурсийн хэмжээнд судлах боломжтой. Бид олон хэлний хэрэглэхүүн дээр хийсэн судлаачдын бүтээлүүдтэй танилцаад дэлхийн олон хэлэнд утгыг үгүйсгэх дараах түгээмэл хэв шинжүүд байна² хэмээн үзэв. Өгүүлбэрийн утгыг:

1. үгүйсгэх үгээр: (*negation word: not, niet, nicht, ne, ne, bu, mei, illa, үл, эс*)
2. үгүйсгэх бүтээврээр: (*negative morpheme: unfriendly, unbekannt, сайнгүй*)
3. үйл үгийн үгүйсгэх хэлбэрээр: (*preverbal, postverbal, pre and postverbal*)
4. үгүйсгэн зохицохуйгаар: (*Negative concord: Никто его невидел (оросоор), Nikdo nic nevyhral (чехээр)*).
5. Хэлцээр: (*phrase/prosentence: no, ne, non, нет, үгүй, хаанаас даа, яриш, дэмий*)
6. үйл үгийн үгүйсгэн захирах хэлбэрээр: (*negative imperative: Nepracuj! (чехээр), Don't read!(англиар), No leas!(учнашар)*)
7. далд хэлбэрээр: (*implicit negation: fail, отказаться, асуух үг бүхий үйл үгийн бүтэцтэй үгүйсгэл: не с кем пойти, оор хэндээ ч итгэх билээ.*)
8. аялгаар: (*intonation: What an original idea!³ Как же дожидайся, буду я молчать!⁴*) үгүйсгэж байна.

Бид энэ өгүүлэлдээ зөвхөн *үгүйсгэн захирах хэлбэрээр* өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэв шинжийг авч үзсэн болно.

1. Монгол Улсын Их Сургууль

2. Энхжаргал Д. Үгүйсгэх утгыг илэрхийлэх олон хэлний түгээмэл хэв шинж. МУИС-ийн ГХСС-ийн Гадаад хэл соёл судлал, 2012, ЭШБ №363(16), 110-120

3. Libuše Dušková a kol. Mluvnice současní angličtiny na pozadí češtiny. Academia Praha, 1994, 336-p тал

4. Д. Э. Розенталь, М.А. Теленкова, Словарь-справочник лингвистических терминов, М, 1976

Д. Энхжаргал

Үгүйсгэлийг дагнан судалсан эрдэмтэд (Zanutini 1998, 2001, Tomic⁵ 1999, Hedde Zeijlstra 2004, Daniël Van Olmen 2011, Johan van der Auwera, Ludo Lejeune⁶) хориглох утгыг үгүйсгэн захирахуй (negative imperative) хэмээн нэрлэдэг.

Үгүйсгэн захирахуйг:

-зөв үгүйсгэн захирахуй (true negative imperative- TNI)

-нөхвөрлөн үгүйсгэн захирахуй (surrogate⁷ negative imperative/suppletive negative imperative⁸-SNI) хэмээн ангилдаг.

Үйл үгийн цагт хэлбэр үгүйсгэл тэмдэглэгчтэй (negative marker) хослон захирах хэлбэр авахыг зөв үгүйсгэн захирахуй гэнэ. Үгүйсгэл тэмдэглэгч хүсэн болзох төлөв эсвэл үйл үгийн тодорхойгүй хэлбэртэй нэгдэхийг

нөхвөрлөн үгүйсгэн захирахуй гэнэ.

Хүснэгт №1

Захирах	Үгүйсгэн захирах	Хэл	Үгүйсгэн захирахуй
pracuj!	Nepracuj!	чех	TNI
работай!	Неработай!	орос	TNI
pracuj!	Niepracuj!	польш	TNI
bad!	Nebadi!	серб-хорват	TNI
Lucreaza !	Nu lucreaza!	румын	SNI
Avod!	Lo avod!	еврей	SNI
work. IMP	NEG work. IMP		
	Битгий ажилла!		

Johan van der Auwera, Ludo Lejeune нар дэлхийн олон хэлэнд хийсэн хэв шинжийн судалгаагаараа хориглох утгыг үгүйсгэн захирахуйн хэв шинжээр нь:

1. энгийн захирах хэлбэр+энгийн үгүйсгэл (normal imperative+normal negative-113 хэл)
2. энгийн захирах хэлбэр+тусгай үгүйсгэл (normal imperative+special negative-182 хэл)
3. тусгай захирах хэлбэр+энгийн үгүйсгэл (special imperative+normal negative-55 хэл)
4. тусгай захирах хэлбэр+тусгай үгүйсгэл- (special imperative+special negative-145 хэл)⁹ хэмээн 4 ангилжээ.

Тэд судалгаагаараа орос (SVO), монгол (SOV), хятад (SOV), япон (SOV), солонгос (SOV) зэрэг олон хэлийг II хэв шинж буюу “энгийн захирах хэлбэр+тусгай үгүйсгэл”-д хамааруулан үзсэн байна.

Судлаач Дакл (Dahl, 1979), Драйер (Dryer, 1988, 1992) нар SOV хэлүүдэд SONegV, SOVNeg гэсэн хоёр төрлийн үгүйсгэл зонхиллогийг ажиглажээ.¹⁰ Драйерийн ажигласнаар

5. Olga Mišeska Tomic Negation and imperative. CatWPL7, 1999, 191-206

6. <http://wals.info/feature/71>

7. Hedde Zeijlstra, Sentential negation and Negative concord. Amsterdam. 2004. 89-р тал

8. Raffaella Zanuttini, Negation and Clausal structure, Oxford university press, 1997, 117-р тал

9. <http://wals.info/feature/71>

10. Guglielmo Cinque, Richard S. Kayne, The Oxford handbook of comparative syntax, chapter 20

Д.Энхжаргал

үгүйсгэл нь SOV хэлбэрийн 117 хэлнээс 15 бүлийн 39 хэл SONegV, 19 бүлийн 64 хэл нь SOVNeg, 5 бүлийн 8 хэл NegSOV, 3 бүлийн 6 хэл нь SNegOV хэлбэртэй байжээ.

Бидний судалгаагаар монгол хэлэнд өгүүлбэрийн утгыг үгүйсгэн захирах өөрийн онцлог дараах шинжүүд байна.

1. Үйл үгийн үгүйсгэн захирах хэлбэр нь ил хэлбэрээр илэрнэ.
2. Үйл үгийн үгүйсгэн захирах хэлбэр нь далд хэлбэрээр илэрнэ.
3. Өгүүлбэрийн утгыг аялгаар үгүйсгэн захирч болно.
4. Хэлцээр үгүйсгэн захирч болно.

1. Үйл үгийн үгүйсгэн захирах хэлбэр нь илээр илрэх нь
(explicit negative imperative)

1.1. “бүү, битгий” үгүйсгэл тэмдэглэгч (negative markers: бь, битги.)

Захирах хүсэх өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйл үгийн захирах хүсэх төлөвийн нөхцөлүүд буюу үйлийн 1-р биений –я (-е, -ё), -сугай (-сүгэй), 2-р биений тэг нөхцөл, –аарай (-ээрэй, -оорой, -өөрэй), -аач (-ээч, -ооч, -өөч), -гтун (-гтүн), -уузай(-үүзэй), 3-р биений –тугай (-түгэй), -аасай (-ээсэй, -оосой, -өөсэй) нөхцөлөөр хэлбэржиж, тухайн үйлийг хэддүгээр биеэр гүйцэтгүүлэх нь төгсгөх нөхцөлийнхээ утгаас ялгарч байдаг¹¹ бөгөөд–уузай (-үүзэй) нөхцөлөөс бусад нь **бүү**, **битгий** гэсэн сул үгсийн тусламжтайгаар үгүйсгэн захирах хэлбэрийг үүсгэдэг байна.

“БҮҮ” –үгүйсгэл тэмдэглэгч

SO+NegV+imp. Affix

бүү +V-е, ё, бүү +V сугай, бүү+V-аарай, бүү+V-аач, бүү+V-гтун, бүү+V-тугай, бүү+V-аасай

...Худалч хүний үгэнд **бүү орьё**. (Монголын нууц товчоо, 149-р зүйл)

...Чи хүнд тустай юм хийж чадахгүй бол хүнд хортой юм **бүү хийгээрэй**. (Ц. Дамдинсүрэн, “Бух Гомбо”)

... “Голомтыг минь **бүү бүрэлгэгтүн**. Бэлгүтэйг **бүү хонөөгтүн**” гээд завилан сууж хүлцэв. (Монголын нууц товчоо, 77-р зүйл)

SO+NegV+ imp. zero

бүү+V +захирах хүсэх төлөв/тэг хэлбэр

...**Ай тэр санал шүүмжлэлийг гаргах хэрэгтэй гэдэг үгэнд бүү хуурт**. (Д. Намдаг, “Тэмцэл”)

“БИТГИЙ”-үгүйсгэл тэмдэглэгч

SO+NegV+imp. affix

Битгий +V-аарай, Битгий+V-аач, Битгий+ V-аасай

Эрээлээд оёсон алчуурыг

Эндэж **битгий гээгээрэй**. (Д. Нацагдорж, “Учиртай гурван толгой”)

SO+NegV+imp. zero

Битгий + V+захирах хүсэх төлөв/ тэг хэлбэр

Preverbal elements in Korean and Japanese, John Witman, Oxford, 2005. 880th page

11. Орчин цагийн монгол хэл, ред Ү. Ариунболд, УБ. 2004, 281-р тал

Д. Энхжаргал

Ах дүү нар сая ижилдэн найрамдаж байгаа тул миний төлөө ах битгий муудалц, хоромхон байзна гэв. (Монголын нууц товчоо, 131-р зүйл)

1.2. -уузай, -үүзэй үгүйсгэл тэмдэглэгч

(-üdzae, üdzэ- negative markers)

Монголч эрдэмтэн, судлаачид II, III биеийн -уузай, -үүзэй нөхцөлийн утгыг *сануулан сэрэмжлүүлэх, анхааруулан болгоомжлох, итгэн хүсэх, болгоомжлох буюу сэжиглэн хүсэх, сэрэмжлэн болгоомжлох, сэжиглэн эргэлзэх, таамаглах ба үл итгэх, анхааруулан сануулах*¹² гэх мэтээр тодорхойлж иржээ.

Үйл үгийн захирах хүсэх төлөвийн -уузай, -үүзэй –нөхцөлийг тухайн үйл явдлаас *урьдчилан болгоомжлох хэлбэр*¹³ (П. Бямбасан 2006), цөм утга нь *сэрэмжлэн болгоомжлох утга* (Ю. Мөнх-Амгалан 1998) хэмээн зарим судлаачид үзсэн байна.

Бидний судалгаанд -уузай, -үүзэй нөхцөл нь үйл үгийг үгүйсгэн захирах утгатай болгож өгүүлбэрийн утгыг үгүйсгэж чадна хэмээн үзэж байна.

Бидний жишээгээр:

... Би харвалдъя гэвэл, Тэмүжин өгүүлрүүн: "Миний төлөө чи эрсдүүзэй. Би харвалдъя" гэж эргэж харвалдав. (Монголын нууц товчоо, 190-р зүйл)

Энэхүү -уузай, -үүзэй нөхцөлтэй үйл үг бүхий өгүүлбэр үгүйсгэх утгатай төдийгүй бусад хэлнүүдэд орчуулбал үгүйсгэсэн утгатай өгүүлбэр байна. Тухайлбал, Чехийн нэрт монголч эрдэмтэн Павел Поухагийн "Монголын нууц товчоо"-ны чех орчуулгад: *Chusar pravil: "Ty nemūzeš. Jā je hudu pronbsledovat!"*, *Temūdzin řekl: "Vy nemūzete. Jā je hudu pronbsledovat!"*¹⁴ хэмээсэн байна.

"Алд бие минь амсу хэмээвээс

Аху төр минь алдруузай." ("Чингисийн билиг")

1.3. "Алга, үгүй" үгүйсгэл тэмдэглэгчүүд тусгай үйл үгтэй хамтран үгүйсгэн захирах

Монгол хэлэнд буй болох гэдэг үйл үг нь алга, үгүй зэрэг үгүйсгэл тэмдэглэгчтэй захирах хэлбэрт хамт хэрэглэгдсэнээр үгүйсгэн захирах утгыг илэрхийлнэ.

SO+NegV+imp. zero Алга +бол Үгүй+бол гэх хэлбэрүүд байж болно.

1.4. "Болохгүй, ёсгүй, хэрэггүй" баймж үгсээр үгүйсгэн захирах

"Ёсгүй, хэрэггүй" зэрэг үгсийг монгол хэлшинжлэлд баймж сул үг, баймж үг, чимэх үг гэх зэргээр нэрлэдэг, харин "болохгүй" нь үйл үг+болно гэсэн бүтэцтэй боломжийн баймж утгыг үгүйсгэсэн хэлбэр хэмээн үзэж байна.

SO+_m V_n neg (Өгүүлэгдэхүүн+тусагдахуун+баймж үйл үг+үгүйсгэл)

...Өвгөдийн хэлдэг нь: "Түймэр гарахад галаас зугтаж болохгүй" (Ц. Дамдинсүрэн "Хув зусаг")

12. Мөнх-Амгалан Ю. Орчин цагийн монгол хэлний баймжийн ай. УБ. 1998. 286-р тал

13. Бямбасан П. Монгол хэлний онол. бүтцийн асуудалд, Үйл үгийн хувилал, 99-р тал

14. Tajná kronika Mongolů. Státní nakladatelství národní literatury, hudby a umění, přeložil Pavel Poucha. Praha. 1955, 35-р тал

Д.Энхжаргал

2. Өгүүлбэрийг далд хэлбэрээр үгүйсгэн захирах

(implicit negative imperative)

Үгүйсгэл тусгай илэрхийлэлгүй байж болно, өөрөөр хэлбэл үгийн утгын бүрэлдэхүүн хэсэг байж болно. Жишээлбэл: орос хэлний (отказаться-(татгалзах) =несогласиться-(үл зөвшөөрөх), англи хэлний fail-(амжилтгүй болох) зэрэг болно. Үүнийг ерөнхий хэл шинжлэлд далд үгүйсгэл (implicit negation¹⁵) хэмээн үздэг. Бидний судалгаагаар тусгай илэрхийлэлгүй үгүйсгэлийн захирах хүсэх хэлбэр нь үгүйсгэн захирахуйн нэг хэлбэр болж байна. Жишээлбэл:

“...Тэгээд Гомбо булуу яс үмхэх гэж байгаа юм шиг амаа их ангайж:

-Ахаа. **Боль доо, боль.** Миний бухыг алж идэх нь үү?...” (Ц. Дамдинсүрэн, “Бух Гомбо”)

3. Өгүүлбэрийг аялгаар үгүйсгэн захирах

(intonational negative imperative)

Хүүрнэх өгүүлбэрийг аялгаар үгүйсгэх хэлбэр дэлхийн олон хэлэнд бий. Хүүрнэх өгүүлбэрийг аялгаар үгүйсгэн захирах хэлбэр мөн байж болохыг монгол хэлний жишээгээр баталж байна. Тухайлбал,

“...**Чи хө, үүнээс хойш манай энэ бууцнаас аргал түүсэн байв аа!**” (Ч. Лувсанжав, “Аргал”) Чи үүнээс хойш манай энэ бууцнаас битгий аргал түүгээрэй гэсэн утга илэрхийлж байна.

4. Өгүүлбэрийг хэлцээр үгүйсгэн захирах

(phrasal negative imperative)

Хэлцээр өгүүлбэрийн утгыг үгүйсгэж болохыг олон судлаачид (Giuliano Bernini, Paolo Ramat 1996¹⁶, Ж. Бат-ирээдүй 2009) тогтоосон байдаг. Хэлцээр өгүүлбэрийн утгыг үгүйсгэн захирах болохыг бидний судалгаа харуулж байна. Жишээлбэл,

...Гавармаа: -Гэвч ээжээ, тэр Банзар чинь над нэг л тусгүй санагдаад байх юм.

Думаа: -**Хош цог!** Юу гэсэн үг вэ?...Чамайг ийм байхад Банзар Норжин руу гүйхгүй яах вэ? (Д. Намдаг, “Амь ба амьдралын үнэ”)

Дариймаа: Тайвшир, битгий хөдөл! Бүү амьсгал! гэхээс өөр юу хэлж чадах юм.

Жав: -**Чин!** Маргаан уу?! (Д. Батбаяр, “Хайрыг хайрла”)

15. Yoko Lyeiri. Verbs of implicit Negation and their complements in the history of English. Amsterdam. 2010, 1-p тал.

16. Giuliano Bernini, Paolo Ramat (1996) Negative Sentences in the Languages of Europe: A Typological Approach. Mouton de Gruyter. Berlin/New York. 89-90-p тал

Д. Энхжаргал
ДҮГНЭЛТ

Үгүйсгэл бол дэлхийн олон хэлэнд байдаг түгээмэл хэв шинжүүдийн нэг. Тэр утгаараа ерөнхий болоод тусгай хэл шинжлэлд судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Үгүйсгэлийн түгээмэл хэв шинжүүдийн нэг болох үгүйсгэн захирахуйгаар өгүүлбэрийн утгыг үгүйсгэх хэв шинжийг сонгон авч судалснаар дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Монгол хэлэнд төдийлэн сайн судлагдаагүй үгүйсгэлийн нийтлэг хэв шинжийн нэг болох үгүйсгэн захирах хэв шинж монгол хэлэнд байна.
2. Монгол хэлнээ өгүүлбэрийн утгыг нь ил. далд, аялгаар, хэлцээр үгүйсгэн захирч (negative imperative) байна.
3. Ил хэлбэрийн үгүйсгэн захирахуй 1) SO+NegV+imp.affix 2) SO+NegV+imp. zero 3) SO+_mV_{neg} гэсэн ерөнхий загвартай.
4. “Бүү, битгий” үгүйсгэл тэмдэглэгч, II, III биеийн -уузай, -үүзэй үгүйсгэл тэмдэглэгч, “алга, үгүй” үгүйсгэл тэмдэглэгчүүд тусгай үйл үгтэй хамтран, “болохгүй, ёсгүй, хэрэггүй” баймж үгсээр өгүүлбэрийг ил хэлбэрээр үгүйсгэн захирдаг.
5. Үгүйсгэн захирахуйн нэг онцлог нь үгүйсгэлийн бусад нийтлэг хэв шинжүүдийг өөртөө багтааж байна.

Монгол хэлэнд үгүйсгэн захирах хэв шинж байхаас гадна, үгүйсгэн захирахуйн олон төрлийн хэв шинж байж болохыг жишээ баримтаар батлав. Үгүйсгэн захирахуй нь бидний судалгаагаар батлагдсан утгыг үгүйсгэх түгээмэл хэв шинжүүд дотроос хамгийн өвөрмөц онцлогтой нь юм.

Д.Энхжаргал

НОМЗҮЙ

- Бат-Ирээдүй Ж. (2009) *Монгол хэлний үгүйсгэх харьцаа ба түүний илрэх хэлбэрүүд*, Токуо University of Foreign Studies
- Бямбасан П. (2006) Монгол хэлний онол бүтцийн асуудалд, УБ
- Мөнх-Амгалан Ю. (1998) Орчин цагийн монгол хэлний баймжийн ай, УБ
- Орчин цагийн монгол хэл (2004), ред Ү. Ариунболд УБ
- Розенталь Д.Э, Теленкова М.А.(1976) *Словарь-справочник лингвистических терминов*, М
- Энхжаргал Д. (2012) *Үгүйсгэх утгыг илэрхийлэх олон хэлний түгээмэл хэв шинж*, МУИС-ийн ГХСС-ийн Гадаад хэл соёл судлал, ЭШБ №363(16), 110-120
- Daniel Van Olmen (2011) *The imperative in English and Dutch, A functional Analysis in Comparable and Parallel Corpora*, Antwerpen
- Giuliano Bernini, Paolo Ramat (1996) *Negative Sentences in the Languages of Europe: A Typological Approach*. Mouton de Gruyter, Berlin/New York
- Guglielmo Cinque, Richard S. Kayne (2005) *The Oxford handbook of comparative syntax. chapter 20, Preverbal elements in Korean and Japanese*, Oxford
- Hedde Zeijlstra (2004) *Sentential negation and Negative concord*, Amsterdam
- Libuše Dušková a kol. (1994) *Mluvnice současné angličtiny na pozadí češtiny*, Academia Praha, 336-337
- Olga Mišeska Tomic (1999) *Negation and imperative*, CatWPL7, 191-206
- Raffaella Zanuttini (1997) *Negation and Clausal structure*, Oxford university press
- Tajná kronika Mongolů (1955), Státní nakladatelství národní literatury, hudby a umění, přeložil Pavel Poucha, Praha
- Yoko Lyeiri (2010) *Verbs of implicit Negation and their complements in the history of English*, Amsterdam
- <http://wals.info/feature/71>

RESUME

Negative imperative is one of sentential negation types. There are four negative imperative types in Mongolian, such as explicit, implicit, intonational and phrasal. Explicit negation has 3 models: SO+ NegV+imp.affix, SO+ NegV+imp.zero, SO+ V' Neg and other negative imperative types have their specularity.